БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/50/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор
2022 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ / эх хувь/ ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11

2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 13

3. Аудитын тайлан ..... 13

3.1 Ерөнхий зүйл ..... 13

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 14

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14

3.4 Материаллаг байдал ..... 15

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 15

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 16

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 17

3.8 Аудитын гол асуудал ..... 17

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 17

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18

4. Аудитын илрүүлэлт ..... 18

**4.1 Залруулсан алдаа** ..... 18

4.2 Зөвлөмж ..... 19

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/81

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.УНДАРМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дан-сны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,817,476.60** | **328,865,835.36** |
| **33** | **АВЛАГА** | 87,702.60 | 286,301,426.36 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 87,702.60 | 229,866.30 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 284,420,500.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 1,651,060.06 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 1,651,060.06 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31,729,774.00 | 42,564,409.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,879,176.00 | 3,224,284.00 |
| 35130 | Эм боох материал | 2,879,176.00 | 3,224,284.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,850,598.00 | 39,340,125.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 858,500.00 | 1,816,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 26,853,098.00 | 36,411,625.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 800,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 224,000.00 | 997,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 115,000.00 | 115,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **898,016,985.53** | **974,590,557.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 898,016,985.53 | 974,590,557.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 854,558,985.53 | 931,132,557.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 860,578,923.01 | 860,578,923.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -107,232,311.87 | -123,962,686.19 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 83,000,000.00 | 47,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,944,999.94 | -20,574,999.90 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 93,787,272.29 | 236,599,129.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -72,212,296.95 | -86,420,444.48 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,732,762.00 | 20,815,762.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,455,267.03 | -10,152,009.56 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,062,200.00 | 10,062,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,757,295.98 | -2,813,317.56 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 43,458,000.00 | 43,458,000.00 |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 43,458,000.00 | 43,458,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **929,834,462.13** | **1,303,456,392.53** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,632,084.00** | **580,027.90** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,632,084.00 | 580,027.90 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 2,632,084.00 | 580,027.90 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 229,147.00 | 229,147.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 328,381.00 | 328,381.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 2,074,556.00 | 22,499.90 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,074,556.00 | 22,499.90 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **927,202,378.13** | **1,302,876,364.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 927,202,378.13 | 1,302,876,364.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 247,732,382.97 | 247,732,382.97 |
| 51101 | Өмч: - төрийн | 247,732,382.97 | 247,732,382.97 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 28,132,635.21 | 403,806,621.71 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 28,132,635.21 | 28,132,635.21 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 375,673,986.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 651,337,359.95 | 651,337,359.95 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **929,834,462.13** | **1,303,456,392.53** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **558,533,200.00** | **1,284,955,398.06** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **81,423,538.00** | **155,261,912.06** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 81,423,538.00 | 155,261,912.06 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 81,423,538.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 81,423,538.00 | 00.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоҮХ | | **129,667,857.56** |
| **120018** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | | **25,594,054.50** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **50,427,698.00** | **1,129,693,486.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 394,400,500.00 | 469,802,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 394,400,500.00 | 469,802,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,497,842.00 | 602,075,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,506,242.00 | 85,915,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 73,400.00 | 00.00 |
| **131107** | **нэмэлт** | | 516,160,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,254,100.00 | 33,083,970.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,254,100.00 | 33,083,970.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 36,957,220.00 | 24,731,416.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 36,957,220.00 | 24,731,416.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **604,970,237.22** | **874,181,411.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **604,970,237.22** | **874,181,411.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 593,363,850.22 | 831,845,938.21 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 327,014,050.00 | 359,091,276.65 |
| 210101 | Үндсэн цалин | 283,553,131.00 | 252,384,105.65 |
| 210102 | Нэмэгдэл | 38,325,000.00 | 70,690,863.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 4,763,778.00 |
| 210104 | Урамшуулал | 5,135,919.00 | 31,252,530.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,224,690.40 | 53,808,783.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,195,563.85 | 38,893,346.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,329,000.26 | 3,775,371.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,639,678.20 | 2,983,335.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 641,858.83 | 741,521.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,418,589.26 | 7,415,207.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,930,195.00 | 32,330,370.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,555,555.00 | 3,288,370.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,974,640.00 | 28,642,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,742,055.00 | 61,032,047.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,192,600.00 | 1,563,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,566,560.00 | 26,818,520.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 762,563.00 | 805,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,308,700.00 | 19,029,152.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 282,500.00 | 335,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,629,132.00 | 12,480,075.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 35,288,354.56 | 104,591,608.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,271,719.00 | 95,881,408.50 |
| 210502 | Хоол, хүнс | 6,723,635.56 | 7,748,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,293,000.00 | 962,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,473,500.00 | 2,061,999.90 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,178,500.00 | 960,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,295,000.00 | 1,101,999.90 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 584,000.00 | 322,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 584,000.00 | 322,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 168,437,631.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 167,987,631.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 125,707,005.26 | 50,170,221.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,525,644.00 | 11,948,935.94 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 110,181,361.26 | 38,221,285.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11,606,387.00 | 42,335,473.35 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,506,242.00 | 42,312,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 11,506,242.00 | 42,312,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 100,145.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 100,145.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 22,973.35 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 22,973.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-46,437,037.22** | **410,773,986.50** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 9,040,268.03 | 35,100,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 9,040,268.03 | 35,100,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -35,100,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-55,477,305.25** | **375,673,986.50** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **477,109,662.00** | **845,272,986.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **477,109,662.00** | **845,272,986.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 394,400,500.00 | 469,802,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,497,842.00 | 317,654,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,506,242.00 | 85,915,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,991,600.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 00.00 | 231,739,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,254,100.00 | 33,083,970.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,254,100.00 | 33,083,970.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 36,957,220.00 | 24,731,416.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 36,957,220.00 | 24,731,416.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **474,878,412.00** | **825,045,986.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **474,878,412.00** | **825,045,986.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **463,272,025.00** | **782,710,512.65** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 326,532,532.00 | 362,067,793.65 |
| 210101 | Үндсэн цалин | 228,990,132.00 | 220,557,828.55 |
| 210102 | Нэмэгдэл | 75,449,400.00 | 106,820,373.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,462,140.00 |
| 210104 | Урамшуулал | 22,093,000.00 | 29,227,452.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,880,700.00 | 44,833,463.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,789,800.00 | 30,369,638.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,265,100.00 | 3,700,933.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,620,200.00 | 2,950,746.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 655,100.00 | 737,685.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,550,500.00 | 7,074,458.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,858,955.00 | 32,583,970.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,555,555.00 | 3,488,370.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,903,400.00 | 28,642,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 453,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22108463.00 | 27791480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,038,000.00 | 1,147,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,570,700.00 | 22,594,480.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 984,263.00 | 974,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,965,500.00 | 1,825,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 550,000.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,703,125.00 | 46,931,206.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 15,451,155.00 | 40,929,806.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,298,970.00 | 5,039,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,953,000.00 | 962,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,786,100.00 | 2,209,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,491,100.00 | 960,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,295,000.00 | 1,249,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 584,000.00 | 322,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 584,000.00 | 322,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 255,091,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 254,641,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,418,150.00 | 10,880,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,418,150.00 | 10,880,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,606,387.00** | **42,335,473.35** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,506,242.00 | 42,312,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 11,506,242.00 | 42,312,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 100,145.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 100,145.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 22,973.35 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 22,973.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,231,250.00** | **20,227,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,231,250.00** | **20,227,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,231,250.00** | **20,227,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,231,250.00 | 20,227,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,231,250.00 | 20,227,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,231,250.00** | **-20,227,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| С08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **28,132,635.21** | **0** | 927,202,378.13 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **28,132,635.21** | **0** | 927,202,378.13 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **28,132,635.21** | **0** | 927,202,378.13 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 375,673,986.50 | 0 | 375,673,986.50 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **247,732,382.97** | **651,337,359.95** | **403,806,621.71** | **0** | 1,302,876,364.63 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 544,347,800.00 | 527,595,312.65 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 544,347,800.00 | 527,595,312.65 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 544,347,800.00 | 527,595,312.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 367,845,900.00 | 362,067,793.65 |
| 210101 | Үндсэн цалин | 222,912,000.00 | 220,557,828.55 |
| 210102 | Нэмэгдэл | 109,896,400.00 | 106,820,373.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,006,000.00 | 5,462,140.00 |
| 210104 | Урамшуулал | 29,031,500.00 | 29,227,452.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,659,200.00 | 44,833,463.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,945,400.00 | 30,369,638.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,678,400.00 | 3,700,933.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,942,800.00 | 2,950,746.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 735,700.00 | 737,685.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,356,900.00 | 7,074,458.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,254,100.00 | 32,583,970.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,150,600.00 | 3,488,370.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,703,500.00 | 28,642,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 453,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,396,200.00 | 27,791,480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,147,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,595,000.00 | 22,594,480.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 976,000.00 | 974,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,375,200.00 | 1,825,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950,000.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 49,450,700.00 | 46,931,206.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 40,940,700.00 | 40,929,806.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 5,039,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,210,000.00 | 962,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,500,000.00 | 2,209,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 960,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,249,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 322,000.00 | 322,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 322,000.00 | 322,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 450,000.00 | 450,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10469700.00 | 10406200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,469,700.00 | 10,406,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 544,347,800.00 | 527,618286.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 469,802,900.00 | 469,802,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 469,802,900.00 | 469,802,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 33,754,100.00 | 33,083970.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 33,754,100.00 | 33083970.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 40,790,800.00 | 24,731,416.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 40,790,800.00 | 24,731,416.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26 | 26 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06. | 06 |

## 2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13497842.00** | **317,654,700.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 274,868,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1991600.00 | 474000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1991600.00 | 474,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 11506242.00 | 42,312,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 13497842.00 | 317654700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13497842.00 | 317654700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11506242.00 | 85,915,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1991600.00 | 00.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 0.00 | 231,739,500.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Ундармаа нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Цэндсүрэн нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Галуут сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар, хүртээмжтэй үзүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын даргын тушаалаар баталгаажуулаагүй байна. Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс нэгдсэн журмаар боловсруулсан салбарын хэмжээнд мөрдөх байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 598,341.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,975.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,731.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,834.5 мянган төгрөг буюу 3,103.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын болон бусад эх үүсвэрийн санхүүжилтийн 317,654.7 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 284,520.5 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1303,456.4 мянган төгрөг болж өмнөх оноос 373,621.9 мянган төгрөгөөр буюу 40,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 31,817.5 | 328,865.8 | 297,048.4 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 87.7 | 286,301.4 | 286,213.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 31,729.8 | 42,564.4 | 10,834.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 898,017.0 | 974,590.6 | 76,573.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,105,069.2 | 1,218,964.0 | 113,894.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (207,052.2) | (244,373.5) | (37,321.3) |
| **Нийт хөрөнгө** | 929,834.5 | 1,303,456.4 | 373,621.9 |
| Өр төлбөр | 2,632.1 | 580.0 | (2,052.1) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 927,202.4 | 1,302,876.4 | 375,674.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 929,834.5 | 1,303,456.4 | 373,621.9 |

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас авав.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,564.4 мянган төгрөг болж 10,834.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 9,558.5 мянган төгрөгөөр , эм, боох боох материалын дансны үлдэгдэл 3,224.3 мянган төгрөг болж 345.1 мянган төгрөгөөр,ЭМД-ын сангаас авах дутуу санхүүжилтийн 284,420.5 мянган төгрөгийн авлага үүссэн нь нөлөөлж байна. Энэ нь Ковид -19 цар тахалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, эмийн нөөцийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,218,964.0 мянган төгрөг болж 113,894.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 20,227.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 26,889.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ЭМГ-аас үнэ төлбөргүй

нийлүүлэгдсэн, хандивын эх үүсвэрээр 102,778.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний 44 тоот тогтоолоор фургон автомашиныг цагдаагийн хэлтэст шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,302,876.4 мянган төгрөг болж 375,674.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал,тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 544,347.8 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна. Анх батлагдсан төсөвт нийт дүнгээр өөрчлөлт ороогүй байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 544,347.8 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 469,802.9 мянга, орон нутгийн төсвөөс 33,754.1 мянга, ЭМДС-гаас 40,790.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 469,802.9 мянга, орон нутгийн төсвөөс 33,083.9 мянга, ЭМД-аас 24,731.4 мянга, нийт 527,618.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 527,595.3 мянган төгрөгийг зарцуулж 22.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 670.2 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 16,059.4 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 527,595.3 мянган төгрөг буюу 96,9 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшуул , ажил олгогчоос төлөх НДШ-ийг 10,603.8 мянган төгрөгөөр, нормативд зардлыг 2,519.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 317,654.7 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 231,739.5 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ,улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Ковид-19 цар тахлын хүрээнд СОК-ын шийдвэрийн дагуу тусгаарлан ажиглах байрыг сургуулийн дотуур байранд 50 ортой, бэлтгэсэн. Мөн тусгаарлах эмнэлгийг 20 ортой бэлтгэсэн ч 8.9 сард өвчлөл эрс нэмэгдсэн учир нэмэлтээр 80 ор дэлгэж нийт 100 ортойгоор эм тариа, халдварын үеийн бэлэн байдлыг хангаж 6 дугаар сарын 10-наас хойш 608 өвчтөнийг хэвтэн эмчлүүлсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 36 асуудал тусгаж хэрэгжилт 85.0%тай гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 874,181.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 269,211.2 мянган төгрөгөөр буюу 44,0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативд зардал 32,290.0 мянга, цалин хөлс нэмэгдэл урамшлын зардал 32,077.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 164,437.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс сар бүр мэдээлэх Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 44,688,2 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 1 мэдээлэл, тухайн

жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 1 мэдээлэл, тендерийн үр дүн гараагүйтэй холбоотой таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 1 мэдээлэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах,өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 1 мэдээлэл, нийт 44,688.2 мянган төгрөгийн 4 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 22594,5 мянган төгрөгийн үнийн дүн бүхий шатах тослох материал харьцуулалтын аргаар худалдан авах тендерийг сумын ЗДТГ зохион байгуулж НИК ХХК-тай гэрээ байгуулсан байна. Эмийн тендерийг аймгийн ЭМГ системийн нэмжээгээр нэгдсэн журмаар зохион байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, хөрөнгийн дахин үнэлгээ данс зөрүүтэй байгааг залруулах үнийн дүнгүй 2 заалт бүхий зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн тухай хариуг 2021.06.18-ны өдрийн №88 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 284,420.5 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,587.0 төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч, 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 44,688.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

**4.1.1.** Горим сорил гүйцэтгэх явцад 2021 оны 12 дугаар сарын халаалтын зардлын 3587,0 мянган төгрөгийг гэрэл, цахилгааны зардалд хаасан, Эмийн зардлын зарцуулалтыг захиалгын хуудастай тулган шалгахад 2021 оны 12 дугаар сард худалдан авсан 3000.0 сая төгрөгийн эмнэлгийн багцыг үлдэгдлээр байхад зарцуулснаар тайлагнасан.

Энэ нь санхүүгийн тайлагналын “Ангилал”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.”Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.” гэснийг үндэслэн санхүүгийн тайланд залруулав.

## 4.2 Зөвлөмж

**4.2.1** Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 44,688.2 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт, 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3.2, 6.4.4, 6.4.8. дахь заалтыг хэрэгжүүлж, хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн мэдээлж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Галуут сумын Эрүүл мэндийн төв | 3 | 6587,0 | 2 | 6587,0 | | | | | 1 | |

______oOo______